

“АДУУНЧУЛУУН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 24/01

Чойбалсан хот

“Түр томилох тухай”


Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.5, 77.6, 79 дүгээр зүйлийн 79.1, 80 дугаар зүйлийн 80.2 дахь заалт, “Адуунчулуун” ХК-ийн дүрмийн холбогдох заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн тухай хуульд заасан шалгуурыг хангасан нэр дэвшигч Цогтсайханы Шижрийг “Адуунчулуун” хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн түр томилсугай.
2. “Адуунчулуун” хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр түр томилогдсон Ц.Шижрийг дээрх хугацаанаас эхлэн хууль болон дүрэмд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхийг зөвшөөрсүгэй.

ГИШҮҮД:



Ш.БАЯСГАЛАН
С.БАДАРЧ
Б.БАТСАЙХАН
ШИДЭР
Т.ДАВААСҮРЭН
Ю.БАТБААТАР
Б.ГАНЧУЛУУН
Т.ДАШ-ЭРДЭНЭ



“АДУУНЧУЛУУН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 02 сарын 14 өдөр

Дугаар... 24/02


Чойбалсан хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг сонгох тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1, “Адуунчулуун” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.30 дахь заалт, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн (цаашид “ТУЗ” гэх) Үйл ажиллагааны журмын 7 дугаар зүйлийн 7.1, 7.3 дахь заалт, ТУЗ-ийн 2024 оны 02 дүгээр сарын 14-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргаар Цогтсайханы Шижирийг сонгосугай.
2. Монгол улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, болон бусад холбогдох хууль тогтоомжууд, Компанийн дүрэм, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмыг мөрдөж ажиллахыг ТУЗ-ийн дарга /Ц.Шижир/-т үүрэг болгосугай.
3. ТУЗ-ийн дарга сонгогдсон талаарх мэдээллийг Компанийн болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж, Хөрөнгийн биржийн цахим хуудас дахь мэдээлэлд холбогдох өөрчлөлт хийхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /А.Оюун-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ГИШҮҮД:



Ш.БАЯСГАЛАН
С.БАДАРЧ
Б.БАТСАЙХАН
ШИДЭР
Т.ДАВААСҮРЭН
Ю.БАТБААТАР
Б.ГАНЧУЛУУН
Т.ДАШ-ЭРДЭНЭ